



Хөв байгуулах Бороо, цасны ус хуримтлуулж, усны нэмэлт эх үүсвэр бий болгох

Тус аймагт өндөр уулын, хуурай хээрийн, цөлөрхөг говь хээрийн бүсийн уур амьсгал зонхилно. Бас чийглэгдүү хүйтэн тагийн хэв шинжийн уур амьсгал өндөр уулын оройн хэсэгт бүрэлддэг боло дулаан говь/цөлийн хэв шинжийн уур амьсгал хагас цөл нутагт илэрдэг. Өндөр уулсын хуурайдуу хүйтэвтэр уур амьсгал нь Монгол Алтайн гол нуруу тухайлбал Мянган Угалзатын нуруу, Бүс хайрхан, Алаг хайрхан, Хар азаргын нуруу, Бурхан буудай уул зэргийн ян сарьдаг, тагаас дооших ар, өвөр хажуу, бэлийн 2000-2800 м-ийн өндөрт бүрэлджээ. Түүнчлэн Монгол Алтайн нурууны хойд салбар Сутай хайрхан, Дарвийн нуруу, Хасагт хайрхан, Хантайширын нуруу болон өмнөд салбар Бурхан буудай уулын тэрхүү хэсэг нь өндөр уулын уур амьсгалтай. Эдгээр өндөр уулсын хуурайдуу уур амьсгалын мужийн 7 дугаар сарын ижил утгын шугам +20 хэм, 1 дүгээр сарын ижил утгын шугам -20 хэм бөгөөд дээрх нутагт жилдээ нийлбэр дүнгээр 80-135 мм орчим хур тунадас унана.

Түр зуурын хур тунадас, хаврын шар усны үерийн усыг хуримтлуулан хадгалах, ганга жалга үүсэхээс хамгаалах зорилгоор байгуулсан Босгоны хөв нь Бигэр сумаас 80 км зайд, далайн түвшнээс 2758.5 метр өндөрт орших бөгөөд Сэрхийн нурууны өвөр талд Дэлгэр сумын төвөөс 15 км зайтай оршино. Хөв байгуулах газар хадан хавцалд орших бөгөөд өвлийн улиралд орсон цас, зуны улиралд орсон борооны усыг цуглуулах, хуримтлуулах зориулалттай юм. Хөвийг хийхдээ далан байгуулж, илүүдэл усыг хаяж байх зориулалт бүхий тусгай илүүдэл ус хаюур хийж өгсөн. Далангийн өндөр 4-5 метр бөгөөд налууд чулуун өрлөг хийсэн нь шүүрлийг багасгаж өгдөг. Уг хөв нь 2000-3000 м³ усыг хуримтлуулах багтаамжтай.

1-р зургийн тайлбар: Хөв байгуулсан газрын төрх байдал
2-р зургийн тайлбар: Хөв



Байршил: Говь-алтай амгийн Бигэр сум, Сэрхийн нуруу

Хөрс, ус хамгаалах арга хэмжээний төрөл: Менежмент
Газар ашиглалтын төрөл: Бэлчээр
Уур амьсгал: Хуурай, сэрүүн
MONCAT мэдээллийн сангийн нэрзүй: QT MON- 21
Холбогдох арга барил:

Бүртгэгдээгүй
Технологийг нэвтрүүлсэн: БОАЖЯ, Говь-Алтай аймгийн БОАЖ-ын газар
Технологийн талаархи мэдээллийг өгсөн : Н.Түвд
Технологийг бүртгэсэн: Л.Мөнхнасан, Ц.Ганчөдөр
 Геоэкологийн хүрээлэн, Цөлжилтийн судалгааны төв.

Он, сар, өдөр: 2009.10.20
Эмхэтгэгчдийн тайлбар: Өндөр уулархаг газрын байршлыг ашиглан цас бороо, үерийн усыг хуримтлуулж болох давуу талтай. Ингэснээрээ хээрийн зэрлэг амьтад болон малыг усаар хангаж усыг зүй зохистой ашиглах нэг үндэс бүрдэх юмаа.

АНГИЛАЛ: Газар ашиглалтын асуудал:


Газар ашиглалт	Уур амьсгал	Доройтлын хэлбэр	Хөрс, ус хамгаалах арга хэмжээний төрөл	
Бэлчээр	Хуурай, сэрүүн	Биологийн доройтол: Биомасс буурсан	Усны доройтол: Хөрс чийгээр дутагдсан	Менежмент Инженерийн байгууламж: хаалт, хашлага хийх
Техник үүрэг/үзүүлэх шууд нөлөө: - Усны хомсдолыг бууруулна - Гадаргын усны нөөцийг нэмэгдүүлнэ			Техник үүрэг/үзүүлэх дам нөлөө: - Бэлчээрийн талхлагдлыг тодорхой хэмжээнд бууруулна.	

ОРЧИН: Байгаль-экологи

Жилийн дундаж хур тунадас (мм)	Өндөршил (д.т.д м)	Гадаргын хэлбэр	Налуужилт (%)
Хөрсний гүн (см) 	Ургамал ургах хугацаа: 120-140 хоног (5-өөс 10-р сар) Хөрсний үржил шим: Дунд Хөрсний бүтэц: Сийрэг Гадаргын чулуурхаг байдал: Чулуурхаг Гадаргын органик бодисын хэмжээ: Дунд зэрэг Хөрсний ус нэвтрүүлэх чадвар: Бага Хөрсний элэгдэл эвдрэлд өртөх байдал: Хүчтэй Ургамалжилт:		Агаарын жилийн дундаж температур: -1.8 C°. Хамгийн их/бага температур: +32/-44 Агаарын хамгийн их/бага даралт: 10 сард 798 /мб/, 4сард 760 /мб/ Агаарын жилийн дундаж даралт: 781.8 /мб/ Нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа: Жилд 2680 цаг, 4р сар буюу хамгийн ихдээ 297 цаг, 12-р сар буюу хамгийн багадаа 148 цаг байдаг байна.

Нийгэм-эдийн засаг

Нэг өрхөд ногдох бэлчээрийн талбай (га) 	Газар ашиглалтын эрх: Нээлттэй Газар эзэмшсэн эсэх: Төрийн/нийтийн Зах зээлийн төрөлжилт: Холимог: амь зуулга/арилжаа наймаа Шаадагдах техник мэдлэг төвшин: Бага: газар ашиглагч ХАА-аас гадна олох орлого, түүний ач холбогдол: 60%	Суурин/нүүдэлчин: Нүүдлийн Ядуурлын төвшин: Бага Ажилгүйдлийн төвшин: Дунд Нигмийн зохион байгуулалт: Дунд
--	--	---



Техникийн зураг:

Далангийн өргөн: 4 метр
 Далангийн өндөр: 7 метр
 Далангийн урт: 20 метр
 Хөвийн багтаамж: 2000-3000 м³

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, үнэ өртөг

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны дараалал

1. Далангийн суурийн хөрсийг авах
2. Далангийн овоолго хийх, түүнийг нягтруулах
3. Элс асгаж өгөх 10 см
4. Нийллэг хальс дэвсэх
5. Чулуун өрлөг 20 см зузаантай хийх
6. Хайрга асгаж өгөх 20 см

Илүүдэл ус хаяур хийх

1. Илүүдэл ус хаях суваг ухах
2. Гараар тэгшилгээ хийх
3. Чулуун өрлөг хийх

Хүн хүчний өртөг

Өндөр
Дунд
Бага

Бусад хөрөнгө оруулалт

Өндөр
Дунд
бага

Хэрэгжүүлэхээд гарах зардал /1 худаг гаргахад/,
 1 \$-ыг 1420 төгрөгөөр бодов

Хөрөнгө оруулалт	өртөг (US\$)	Газар ашиглагча ас гарах %
Тээвэрлэх шатахууны зардал	22	0%
Материалыг худалдан авах	62	0%
Нийт	84	

Үнэлгээ

Давуу тал ба/буюу → хэрхэн тогтвортой байлгах/сайжруулах

Цас бороо, үерийн усыг ашиглах боломжтой → Сум орон нутгаас хөв байгуулах боломжтой газруудад технологи дамжуулахад онцгой анхаарч мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах

Үерийн усаар ганга, гуу жалга үүсэж хөрс эвдрэхээс сэргийлнэ →

Бэлчээрийн мал, ан амьтдыг услах усан хангамж сайжирна → Шаардлагатай тохиолдолд хөрөнгө санхүүгийн асуудлыг төр, орон нутгийн зүгээс шийдвэрлэж байх

Сул тал ба/буюу → хэрхэн даван туулах

Хөвийн ойр орчим мал амьтны хөлд талхлагдаж болзошгүй → ойр орчимд ургамлан нөмрөгийг сайжруулах арга хэмжээ авах

Салхиар туугдаж ирсэн хог хөв дотор хуралдах сөрөг талтай → тодорхой хугацаанд лайдаж, цэвэрлэгээг хийх

Холбоо барих байгууллага: ШУА-ийн Газараүй - Геоэкологийн хүрээлэн: Цөлжилтийн судалгааны салбар
Утас: 976-11-325487 **Факс:** 976-11-322187
Вебсайт: www.igg.ac.mn, www.geo-eco.mn